



DARIFINANCE
non-banking financial institution

*"Дарь Финанс ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн
ТУЗ/24/01 дугаар тогтоолын хавсралт №06*

ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Хувилбар № 1

Улаанбаатар хот
2024 он

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү баримт бичгээр компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 1.2 Бодлогын зорилго нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах албан тушаалтны олон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.

Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-д танилцуулна.
- 2.2 Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчдийг тодорхойлж, санал болгоно.
- 2.4 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсвэл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.5 Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

Гурав. Хяналт

- 2.6 Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.